



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

№111 /555/

2023.07.19

Цаг үе, үйл явдал

АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзэл" явуулах ажлын хэсэг өнөөдөр хуралдлаа.

Хуралд Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бригадын генерал Б.Баасандамба, ажлын хэсгийн дарга, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, дүрэмч-жагсаалч байдал, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин, цэргийн сургалт бэлтгэлийн явц, чанар, орчин, өнөөгийн байдлыг бодитоор тогтоож, цаашид цэргийн алба хаагчдад чиглэсэн сургалт бэлтгэлийг сайжруулах арга

замыг оновчтой тодорхойлох зорилгоор энэхүү үзлэгийг 3 үе шаттайгаар зохион байгуулж байна.

Энэ хүрээнд I, II шатны үзлэгийн нэгдсэн дүн, тайланг дэмжлэг үзүүлэх бүлгийн дэд дарга, ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын даргын орлогч хурандаа Д.Жигжидсүрэн танилцуулла. Үүний дараа үзлэгийн дүнтэй холбоотойгоор ажлын хэсгийн гишүүд санал, хүсэлтүүдээ уламжлав.

Хурлын дэгийн дагуу III шатны үзлэгийн удирдамжийн төслийг танилцуулж, зохион байгуулалт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гишүүд хэлэлцүүлэг өрнүүлэв.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бригадын генерал Д.Баасандамба ажлын хэсэгт чиглэл өглөө.

Үргэлжлүүлэн Бригадын генерал Ж.Болдбаатар дэд ажлын хэсгүүд нэгдсэн байдлаар хамтран ажиллаж, дүнгээ гаргах, түвшин тогтоох I, II

шатны үзлэгийн явц, хэрэгжилт, дараагийн шатны зохион байгуулалтын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр өргөн хүрээнд сурталчлах, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ цэргийн алба, сахилга, дэг журам, ёс зүйг чанд сахихыг захив.

Тэрээр гуравдугаар шатны үзлэгт мэргэжлийн төв байгууллагын хурандаа ба түүнээс дээш зэрэглэл бүхий албан тушаалд ажиллаж байгаа ахлах, дээд офицеруудыг үзлэгт хамруулахтай холбоотойгоор төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын манлайлал, ёс зүйн түвшнийг судалж, бодит дүгнэлт гаргах ёстой гэдгийг хөндлөө.

Мөн өөрсдийн харьяа нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн арга зүйн удирдамжаар хангах, батлагдсан хуваарийн дагуу алба хаагчдыг бүрэн хамруулах ёстой

гэв. Үзлэгийн үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, офицер, ахлагчийн бие бялдрын бэлтгэлжилт, албаны манлайллыг хөгжүүлэх, нийгмийн хамгаалал, сургаж бэлтгэх орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг тодорхойлоход чиглэсэн бодлогын баримт бичгийг, шинэчлэх, сайжруулахад шаардлагатай саналыг боловсруулахыг үүрэг болгов.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох III шатны үзлэг нь төрийн тусгай алба хаагчдын бие бялдраа хөгжүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах, дүрэмт хувцасны зохистой хэрэглээ, ёс зүйн түвшнийг дээшлүүлэх үндсэн зорилготойгоос гадна байгууллагуудын хоорондын нэгдмэл байдлыг сайжруулах ач холбогдолтой юм.



“ШИЙДЭМГИЙ ШИЙДВЭР-2023” СУРГУУЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО



Катар Улсын Зэвсэгт хүчинтэй хамтарсан “Шийдэмгий шийдвэр-2023” сургуулийн нээлтийн үйл ажиллагаа Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд боллоо.

Нээлтийн үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний ТХЦ-ийн командлагч бригадын генерал Б.Баатар, АЦК-ын штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат, Катар Улсын БХЯ-ны Монгол-Катарын харилцааг хариуцсан дарга бригадын генерал Набеел Сорур, ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд тэргүүтэй хүндэт зочид болон “Шийдэмгий шийдвэр-2023” сургуульд хамрагдах цэргийн алба хаагчид оролцлоо.

Хамтарсан сургуулийг нээж Зэвсэгт хүчний ТХЦ-ийн командлагч бригадын генерал Б.Баатар хэлсэн үгэндээ “уг сургууль нь хоёр улсын Зэвсэгт хүчний шилдэг дайчид өөрсдийн хуримтлуулсан туршлага, сургамж ба үйл ажиллагаагаар

нь туршигдаж батлагдсан ажиллагааны арга техникүүдийг харилцан бие биедээ зааж сурган, туршлага мэдлэгээ хуваалцах өргөн боломжийг бүрдүүлдэг болохыг онцлоод сургуулийг хамтран зохион байгуулж байгаа Катар Улсын Зэвсэгт хүчний удирдлага ялангуяа бригадын генерал Набеел Сорур болон түүний багийнханд чин сэтгэлийн талархал илэрхийллээ.

Үргэлжлүүлэн Катар Улсын талын сургуулийн удирдагч Али Хаади Алхажри хэлсэн үгэндээ уг сургуулийг зохион байгуулахад гол дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Зэвсэгт хүчинд талархаж буйгаа илэрхийлээд “Шийдэмгий шийдвэр” сургууль нь Катар улсын сонсогч, офицеруудад олон зүйл сурах боломжийг олгоор ирснийг онцлов.

“Шийдэмгий шийдвэр-2023” хамтарсан сургууль нь 7 сарын 19-ний өдрөөс 8 сарын 7-ны өдрийн хооронд үргэлжлэх бөгөөд Катар Улсаас

450, Монгол Улсаас 100 гаруй цэргийн алба хаагчид оролцож байна.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,425	3,433
EUR 🇪🇺	3,742	3,758
CNY 🇨🇳	475.90	479.10
RUB 🇷🇺	38	39.10
JPY 🇯🇵	22.20	23.70
KRW 🇰🇷	2.62	2.63

ЗУРХАЙ

2023.07.19 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 2

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР

Үс засуулбал:
Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
05.13-20.44
Барилдлага:
Рашаан
Шүтэн барилдлага:
Хурьцахуй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,020,556

Эдгэрсэн

Нийт: 663,950,020

Нас барсан

Нийт: 6,903,659

Цахим шууданд

БИДНИЙ ОНЖАВ ДЭД ХУРАНДАА
Б.ОЮУНТҮЛХҮҮРТ ХАНДИВЫН ГАРАА
СУНГАХЫГ УРИАЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 186 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа дайчны гэр бүлд иж бүрэн өргөө цагаан гэр олгуулсан гээд түүний ажлаасаа гадна бусдын төлөөх үйлс нь хязгааргүй билээ. Бидний онжав одоогоор Орхон аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа тул Зэвсэгт хүчний мөрдэс нэгт нөхөд, ҮБХИС-ийн үе үеийн төгсөгчид, энхийг сахиулагч дайчид, сайхан сэтгэлт түмэн олныг найзад минь амьдрал бэлэглэхийг хичээнгүйлэн хүсэж байна.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай
ХАНДИВЫН ДАНС: Хаан банк 5098023110
ХАРИЛЦАХ УТАС: 88048303 эхнэр

Б.Одончимэг
1999-2003 ОНЫ ЦНДС-ИЙН
ОНЖАВУУДААС НЬ



Цэрэг дайчид гэхээр л орон нутгийнхаа хөрөнгө оруулалтаар туслуулах гээд гүйж явдаг, цэрэг татлага болохоор төр, ард түмний холбогч нь болж, Зэвсэгт хүчнээ сурталчлан дайчилгааны хүний нөөцийг бүрдүүлж гүйдэг Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Б.Оюунтүлхүүрт мөрдэс нэгт нөхөд, сайхан сэтгэлт түмэн олны тусламж юу юунаас илүү хэрэгтэй боллоо.

2023 оны гуравдугаар сард элэгний цироз хэмээх өвчнөөр оношлогдож, гадаадад цаг алдалгүй яаралтай эмчлүүлэхэд 200-250 сая төгрөгийн зардал шаардлагатай болсон тул та бүхнээсээ тусламж хүсэж байна. Дэд хурандаа Б.Оюунтүлхүүр нь Зэвсэгт хүчинд 24 дэх жилдээ алба хааж байгаа, ажлын гараагаа 2003 онд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангиас эхлүүлсэн офицер. Тэрээр Орхон хүрээний цэргийн анги байгууллага бүртээ нутгийн удирдлагуудаас тусламж дэмжлэг үзүүлэхэд гүүр нь болж, хүний төлөөх, албаныхаа төлөөх сэтгэлтэйгээрээ онжавууддаа төдийгүй Зэвсэгт хүчиндээ танигдсан залуу. Саяхандаа л гэхэд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангид иж бүрэн хөгжмийн зэмсэгийг орон нутгаасаа гаргуулж,

ТОРГОН ЦЭРГҮҮД ХӨШӨӨНИЙ НЭЭЛТЭД
ОРОЛЦОВ



тоглолтыг толилуулсан нь цэрэг эх оронч үзэл, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлсэн ажил арга хэмжээ боллоо. Мөн ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн урлагийн тоглолт ойг чимж, эх оронч үзлийг бадрааж өгсөн юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА



Монгол Улсын төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Жамсрангийн Ёндон агсны мэндэлсний 100 жилийн ойд зориулсан хөшөөний нээлт түүний төрөлх нутаг болох Сүхбаатар аймгийн Мөнххаан суманд сүндэрлэн бослоо.

Мөнххаан сумын түүхт 100 жилийн ойн баярын өдөр хөшөөний нээлтийн ёслолыг зохион байгуулж, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Хүндэт харуулын тусгай ротын бие бүрэлдэхүүн уригдан ирсэн хүндэт зочид, нутгийн ард иргэдэд жагсаалын үзүүлэх

Уриалга

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА



ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧДЫН
БЭСРЭГ НААДМААР ...



БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангид Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн албаа нэр төртэй хааж буй дайчид Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан "Бэсрэг наадам"-аа хийлээ.

Тус ангийн захирагч, дэд хурандаа Д.Бямба дайчдын наадмыг нээж хэлсэн үгэндээ "Тулгар төрийн 2232 Их Монгол Улс үүсэн байгуулагдсаны 817, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Дорнод аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баярын мэндийг эрхэм түрүүч, байлдагч нартаа хүргэе. Хугацаат цэргийн алба хаагчид Та бүхэн эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх, эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэхэд манлайлах ёстой" гээд уламжлалт баяр наадам,

үндэсний ёс заншлаа эрхэмлэж явахыг захисан юм.

Бэсрэг наадмын хүчит 32 бөхийн барилдаанд Хэнтий аймгийн Батноров сумын харьяат дэд түрүүч Б.Бат-Эрдэнэ түрүүлж, Дорнод аймгийн Булган сумын харьяат байлдагч Г.Гансүх үзүүрлэж, дэд түрүүч С.Энхсүх, дэд түрүүч Г.Төртөгтох нар шөвгөрлөө.

Шагайн харвааны цуваа харваагаар байлдагч Д.Ширнэнлүг тэргүүн байрт, байлдагч Б.Билгүүнбаяр дэд байрт тус тус шалгарав.

Үндэсний сур харвааны төрөлд байлдагч Д.Анхбаяр, байлдагч О.Эрдэнэсүмбэр нар цэц мэргэн байж, тэргүүн байруудыг эзэлсэн бөгөөд ангийн удирдлагууд эрийн гурван наадмаараа тэргүүлсэн дайчдад гарын бэлэг гардуулж баяр хүргэлээ.

Ахлах дэслэгч
Л.МӨНХЧӨДӨР



НЭЭЛТТЭЙ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ
БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2023-2024 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан (офицер), цэргийн мэргэжилтний (цэргийн ажиглагч, холбогч офицер) сонгон шалгаруулалтыг 2023 оны 09 дүгээр сарын 04-нөөс 09 дүгээр сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ.

- Үүнд: 1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт;
3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
4. Гадаад паспортын хуулбар;
5. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
6. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
8. Товч судалгаа (доорх хүснэгтийн дагуу бөглөх);

Анг	Албан тушаал	Цол	Өвөг нэр	Нас, хүйс	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа төгссөн байдал	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон өгнөө	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал	Англи хэлний түвшин тогтоох шалгалтын өгнөө (Хамгийн сүүлд өгсөн АLCPT, ECL, TOEFL, IELTS)
-----	--------------	-----	----------	-----------	--	-------------------------------------	--	---------------------------------	--

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэс psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3679, 99732447, 88689855, 70152660/-тай холбогдож тодруулна уу. "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmaf.gov.mn/gsmaf/cat/60> холбоосоор орж танилцана уу.

ЗХЖШ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ, ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАНЫ ХЭЛТЭС